



III/2022


Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 13



Үнэмлэхүй их температур 2022 оны 3 дугаар сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд 19.6⁰C-д хүрсэн байна

Агаарын үнэмлэхүй их температур 2022 оны 3 дугаар сард Өмнөговь аймгийн Ханбогд суманд 19.6⁰C, үнэмлэхүй бага температур Завхан аймгийн Цэцэн-Уул суманд -35.0⁰C-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (⁰C), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар



¹ - Сүүлийн 30 жил

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2022 оны 3 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр хэмжээ Дорнод аймгийн Халхгол суманд 14.3 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Өвөрхангай аймгийн Хархорин суманд 39 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар


Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2022 оны 3 дугаар сард Цахилгаан станц, Зуун айл, Мишээл экспо төв, Баруун дөрвөн зам, Таван буудал, Хайлааст, Баянхошуу, Нисэх, Амгалан, Тахилт, Зурагт орчимд 0.057мг/м³-0.343 мг/м³-д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас 0.007мг/м³-0.293 мг/м³-ээр буюу 14.0 хувиас 6.9 дахин их байна.

Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2022 оны 3 дугаар сард Богд хааны ордон музей, Цахилгаан станц, 13-р хороолол, Тахилт, Баруун дөрвөн зам орчимд 0.052 мг/м³-0.099 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.002 мг/м³ -0.049 мг/м³- ээр буюу 4.0-98.0 хувиар их байна.

Харин PM 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2022 оны 3 дугаар сард Богд хааны ордон музей, Таван буудал, Ургах наран хороолол, Баруун дөрвөн зам, 13-р хороолол, Хайлааст, Тахилт, Цахилгаан станц, Нисэх, Зуун айл орчимд 0.128 мг/м³ – 0.277 мг/м³-д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.028 мг/м³ – 0.177 мг/м³-ээр буюу 28.0 хувиас 2.8 дахин их байна.

Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5 тоосонцрын дундаж агууламж 2022 оны 3 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.002мг/м³ (4.4%)-ээр, хүхэрлэг хийн дундаж агууламж 0.004мг/м³ (5.7%)-ээр, азотын давхар ислийн дундаж агууламж 0.007мг/м³ (19.4%)-ээр их байсан бол PM 10 тоосонцрын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.007 мг/м³ (6.9%)-ээр бага байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 3 дугаар сарын байдлаар, мг/м³



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 982 болж, өмнөх оны мөн үеэс 138 (12.3%) -аар буурсан байна. Газар хөдлөлт 2022 оны 1 дүгээр улирлын байдлаар 18 удаа бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 186 (91.2%) -гаар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны 1 дүгээр улиралд нийт 23 хүн амь насаа алдаж, өмнөх оны мөн 46 (66.7%) -гаар буурсан байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2022 оны 1 дүгээр улиралд 3.0 тэрбум төгрөгийн хохирол учирч, 0.5 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ², жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Үзүүлэлт	2019 I-III	2020 I-III	2021 I-III	2022 I-III	2022 I-III
					2021 I-III
					хувь
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	1 315	973	1 120	982	87.7
Газар хөдлөлтийн тохиолдлын тоо	11	17	204	18	8.8
Объектын түймрийн тоо	1 200	772	753	790	104.9
Амь насаа алдсан хүний тоо	29	41	69	23	33.3
Учирсан хохирол, тэрбум төгрөг	3.5	4.2	7.0	3.0	42.9
Зарцуулсан зардал, сая төгрөг	508.3	50.7	377.6	512.6	135.8

² - Корона вируст халдварын тохиолдлын тоо болон түүнтэй холбоотой гарсан зардлыг оруулаагүй.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол: Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр:

Цаг уур, орчны шинжилгээний газар;
Онцгой байдлын ерөнхий газар;

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 5 дугаар сарын 17

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212